



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 266

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг хүлээн
авахыг түр зогсоох тухай

Биржийн арилжааны танхимын техникийн нөхцөл хязгаарлагдмал, зориулалтын бус тул арилжааны танхимын 32 суудлын тоог нэмэгдүүлэх боломжгүй талаар “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн 2013 оны А/074 тоот албан бичиг ирүүлсэн, Санхүүгийн зохицуулах хорооноос биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 33 хуулийн этгээдэд олгосон зэргийг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөдөө аж ахуйн биржийн байнгын гишүүн оролцогч биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар Хороонд гаргасан хүсэлтийг хүлээн авахыг 2013 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар түр зогсоосугай.

2.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000430